



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 09 сарын 04 өдөр

Дугаар 99

Улаанбаатар хот

**“Монгол наадам цогцолбор” төслийн нэгж орон
нутгийн өмчит, төсөвт үйлдвэрийн газрыг
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “ж”, 20 дугаар зүйлийн 20.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4, Иргэний хуулийн 30 дугаар зүйлийн 30.2, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас 2013 оны 1/2980 дугаар албан бичгээр өргөн барьсан саналыг тус тус үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Монгол наадам цогцолбор” орон нутгийн өмчит, төсөвт үйлдвэрийн газрыг 2013 оны 09 дүгээр сарын 04-ний өдрөөс байгуулсугай.

2. “Монгол наадам цогцолбор” орон нутгийн өмчит, төсөвт үйлдвэрийн газрын дүрмийг хавсралтаар баталсугай.

3. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Э.Бат-Үүл/-д ДААЛГАХ нь:

3.1. “Монгол наадам цогцолбор” орон нутгийн өмчит, төсөвт үйлдвэрийн газрын бүтцийг баталж, удирдлагуудыг томилж ажиллуулах;

3.2. “Монгол наадам цогцолбор” орон нутгийн өмчит, төсөвт үйлдвэрийн газрын төсөв, санхүүжилтийн талаар саналын төсөл боловсруулж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар нэн даруй оруулж хэлэлцүүлэн, шийдвэрлүүлэх;

3.3. Ажил үйлчилгээг хэвийн хэмжээнд явуулах, өмч хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж ажиллах.

ДАРГА  Д.БАТТУЛГА



135

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2013
оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн
99 тогтоолын хавсралт

**“МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР”
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗРЫН ДҮРЭМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Монгол наадам цогцолбор” нь Улаанбаатар хотын орон нутгийн өмчийн өөрийн балансад бүртгэгдсэн эд хөрөнгө, дүрмээр хүлээсэн эрх, үүргийн хүрээнд ажиллаж, Монгол наадам цогцолборын хүрээнд бүтээн байгуулагдсан нийтийн зориулалттай орон нутгийн өмчийг олон нийтийн арга хэмжээ, баяр наадам зохион байгуулах, талбай, эд хөрөнгийн ашиглалт, засвар үйлчилгээг хариуцах Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар /ОНӨТҮГ/ мөн.

1.2 “Монгол наадам цогцолбор” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар нь ОНӨТҮГ /цаашид Газар гэх/ Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төсвийн тухай, Газрын тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Хөдөлмөрийн тухай, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн тогтоол, Засаг даргын захирамж, мөрийн хөтөлбөр, энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

1.3. Газрын дүрмийн зорилго нь өөрийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг тогтоох, удирдлага, зохион байгуулалтын бүтэц, хяналт, үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх, түүнийг өөрчлөн байгуулах, бүртгүүлэх зэрэгтэй холбогдох үйл ажиллагааны харилцааг зохих хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулахад оршино.

1.4. Газрын /ОНӨТҮГ/ өмчлөгч нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байх бөгөөд төлөөлөл хэрэгжүүлэгч нь Нийслэлийн Засаг дарга, түүнээс эрх олгосон төрийн захиргааны байгууллага болох Нийслэлийн Өмчийн Харилцааны газар байна.

Хоёр. Хэлбэр, оноосон нэр, байршил, тэмдэг

2.1. Газрын оноосон бүрэн нэр нь “Монгол наадам цогцолбор” Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар байх ба товчилсон нэр нь “МНЦ” ОНӨТҮГ байна.

2.2. Газрын оршин байх газар нь: Монгол улс. Улаанбаатар хот.

2.3. Газрын шуудангийн хаяг: Монгол улс

2.4. Электрон шуудангийн хаяг:

2.5 Газар нь тогтоосон журмын дагуу хийгдсэн билэгдэл, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, нийслэлийн төрийн сан банкинд харилцах данстай байна.

2.6 Билэгдэл, тэмдгийн загварыг баталж, Оюуны өмчийн газарт бүртгүүлсэн байх бөгөөд түүний хэрэглэх эрхийг эдэлнэ.

2.7 Тэмдгээр үйлдвэрийн газрын албан ёсны шийдвэр, албан бичиг, гэрээ хэлцлийг баталгаажуулна.

2.8 Тэмдгийг үйлдвэрийн газрын даргаас итгэмжлэн хариуцуулсан этгээд түшиж, ашиглалт, хамгаалалт, хадгалалтыг хариуцна.

Гурав. Үйл ажиллагааны зорилго, үндсэн чиглэл

3.1. Газрын зорилго нь Монгол наадам цогцолборын хүрээнд хийгдсэн бүтээн байгуулалт, тохижилтын ажлыг хүлээн авах, түүнтэй холбогдон үүсэх эрх, үүрэг, хариуцлагыг хүлээж олон нийтийн арга хэмжээ, баяр наадам зохион байгуулах, зам талбай, авто зогсоол, түүний эд хөрөнгө, инженерийн шугам сүлжээ, техник тоног төхөөрөмж, тохижилтын бүрэн бүтэн байдал, ашиглалтыг хариуцан ажиллахад оршино.

3.2. Газар нь өөрийн хүчин чадлыг нь бүрэн ашиглан Төрийн ёслол, Улсын баяр наадам, тив улсын чанартай спортын болон сонирхогчдын тэмцээн, уралдаан, спортын төрөл бүрийн арга хэмжээ, шоу болон цэнгээнт арга хэмжээ, гадаад болон дотоод худалдаа, нийтийн амралт, зугаалга, үйлчилгээ зэрэг арга хэмжээнд нийтийн эзэмшлийн барилга байгууламж, автозам, талбай, тоног төхөөрөмжийг түрээслүүлэх, төлбөртэй үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа явуулна.

3.3 Газар нь гадаад, дотоодын холбогдох байгууллагуудтай зохих журмын дагуу харилцаа холбоо тогтоож, хамтран ажиллах, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх эдлэх, үүрэг хүлээх, түүнчлэн хуулийн байгууллагад нэхэмжлэгч, хариуцагчаар оролцоно.

3.4. Газар нь цогцолборын чадавхийг хөгжүүлэх, материаллаг баазыг хамгаалах, түүнийг бэхжүүлэх, барилга байгууламжийг засварлах, шинэчлэх, ашиг орлогыг нэмэгдүүлэх бизнесийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллана.

3.5. Газар нь олон нийтийн арга хэмжээ, баяр наадмын үйл ажиллагааг хэвийн явуулах, цахилгаан эрчим хүч, усан хангамжийн хэвийн ажиллагаагаар хангах, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол үзүүлэх, бусад ногоон байгууламж, тохижилт үйлчилгээний стандартыг мөрдөж ажиллах талаар холбогдох байгууллагуудтай ажлын уялдаа холбоотой ажиллана.

3.6 Нийслэлийн өмчит барилга байгууламж, автозам, талбай, тоног төхөөрөмж, эд хогшлыг ашиглуулах, төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээний хөлс, үнэ тарифыг зах зээлийн судалгаанд үндэслэн бизнес төлөвлөгөөтэй уялдуулан жил бүр шинэчлүүлж Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулж мөрдөнө.

3.7 Газар нь Монгол наадам цогцолборын хүрээнд хийгдсэн барилга, байгууламж, түүний эд хөрөнгө, инженерийн шугам сүлжээ, ус худаг, зам талбай зэрэг бүх барилга байгууламж, тохижилтын ажлыг ашиглалтанд хүлээн авахад оролцож, саналаа илэрхийлэн акт, баримт бичигт холбогдох этгээд гарын үсэг зурна.

Дөрөв. Удирдлага, зохион байгуулалт

4.1 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн санал болгосноор Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ыг үүсгэн байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг шийдвэрлэнэ.

4.2 Газрын өдөр тутмын үйл ажиллагааг дарга удирдана. Даргыг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн саналыг үндэслэн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч томилж, чөлөөлнө.

4.3 Газар нь үйл ажиллагаагаа Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн шууд удирдлага дор явуулж, ажлаа тайлагнана.

4.4. Газрын даргын эзгүйд түүний эрх, үүргийг Захиалагч менежер хэрэгжүүлж ажиллана.

4.5. Дарга нь “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-д заасан шалгуурыг хангасан байна.

4.6. Газрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг Улаанбаатар хотын Ерөнхий менежертэй зөвшилцөн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч тогтооно.

4.7 Газрын санхүүжилт нь нийслэлийн жил бүрийн төсөвт тусгагдан батлагдана.

4.8 Газрын даргын ажил, үйлчилгээний үр дүнгийн гэрээг дүгнэх, цалин хөлс, шагнал урамшуулал олгох, хариуцлага тооцох асуудлыг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн саналыг үндэслэн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч шийдвэрлэнэ.

4.9 Газрын дарга нь Нийслэлийн төсвийн Ерөнхийлөн захирагчтай ажил, үйлчилгээний үр дүнгийн гэрээ, Нийслэлийн өмчийн харилцааны газартай контракт гэрээ, үйл ажиллагааны ерөнхий чиглэл, бусад асуудлаар Ерөнхий менежертэй тус тус гэрээ байгуулан ажиллана.

4.10 Дарга нь дор дурдсан эрх, үүрэгтэй байна.

4.10.1. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд, газрын дүрэм, зорилтын санал, бизнес төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;

4.10.2. Байгууллагын санхүүгийн төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, төсөв болон үйл ажиллагааны орлогыг дүрэмд заасан үйл ажиллагаа, батлагдсан төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор зарцуулах;

4.10.3. Эрхлэх ажлын чиг үүрэг, олгогдсон эрх хэмжээний хүрээнд гэрээ байгуулах;

4.10.4. Эрхлэх ажлын хүрээнд холбогдох хууль тогтоомж, дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх үүднээс эрх зүйн зохицуулалт, зохион байгуулалтыг сайжруулах асуудлаар шийдвэрийн төсөл, санал боловсруулж холбогдох байгууллагад уламжлах ;

4.10.5 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас баталсан удирдлагын бүтэц, зохион байгуулалтын хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, цалингийн хэмжээ, урамшууллын журмыг тогтоох, хууль тогтоомжийн хүрээнд ажлаас чөлөөлөх;

- 4.10.6. Дарга нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу эрх хэмжээнийхээ хүрээнд Монгол улсын хууль тогтоомжид нийцүүлэн тушаал гаргана.
- 4.10.7. Хууль тогтоомж болон гэрээгээр олгосон бусад эрх үүрэг эдэлнэ.

Тав. Санхүүжилт, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан

5.1. Газар нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу жил бүр гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна.

5.2. Газрын санхүүгийн тайлангийн үнэн зөвийг дарга, ахлах нягтлан бодогч нар хариуцна.

5.3. Газрын ахлах нягтлан бодогч нь бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй системийн байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан байна.

5.4. Газрын санхүүгийн жил нь тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, мөн оны 12-р сарын 31-ний өдөр дуусгавар болно.

5.5 Газрын орлого нь дараах санхүүгийн эх үүсвэрээс бүрдэнэ:

5.5.1. Улсын болон нийслэлийн төсвийн санхүүжилт

5.5.2. Ажил, үйлчилгээ, түрээсээс олсон бүх орлого;

5.5.3. Байгууллагатай хамтарч ажиллах гэрээний дагуу олсон үйлчилгээний орлого;

5.5.4. Хандивлагч орнуудын зээл, тусламж болон буцалтгүй тусламж;

5.5.5. Хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр;

5.6 Дарга нь Нийслэлийн өмчийн харилцааны газарт тухайн жилийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, зарцуулсан хөрөнгө санхүү, үр дүнгийн талаар тодорхой тусгасан тайлан илтгэх бичиг хүргүүлэх бөгөөд тайланд дараах зүйлийг тусгана:

5.6.1. Тайлангийн хугацаанд эрхлэн явуулсан үндсэн үйл ажиллагааны талаархи танилцуулга, гарсан өөрчлөлтүүд болон эдгээр үйл ажиллагааны үр дүнгийн байдал, түүний өөрчлөлт;

5.6.2. Тайлангийн хугацаанд албан тушаалтан, ажиллагсад олгосон шагнал урамшил, удирдлагын зардлын хэмжээ;

5.6.3 Шаардлагатай бусад мэдээлэл, тайлбар;

Зургаа. Эд хөрөнгийн эрх

6.1. Газар нь өөрийн эзэмшиж байгаа эд хөрөнгийн хэмжээгээр эрх эдэлж, хариуцлага хүлээнэ.

6.2. Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтанд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг Нийслэлийн Засаг даргын өмнө газрын дарга, бүртгэлээр тавих хяналт, шалгалтыг газрын нягтлан бодогч хариуцна.

6.3. Газар нь эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй байна:

6.3.1. Өөрт олгогдсон үл хөдлөх хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах;

6.3.2. Үндсэн хөрөнгийг Нийслэлийн өмчийн харилцааны газартай байгуулсан контракт гэрээгээр олгосон эрх хэмжээний дотор захиран зарцуулах;

6.4. Газар нь үндсэн хөрөнгийг зөвхөн Нийслэлийн өмчийн харилцааны газрын шийдвэрийг үндэслэн бүртгэж авах, акталж данснаас хасах, худалдан борлуулах, устгах, шилжүүлэх эрхтэй.

6.5. Газар нь тухайн жилд хийгдэх их болон урсгал засварын нэгдсэн төлөвлөгөө, төсвийг Улаанбаатар хотын Ерөнхий менежерээр батлуулсны дараа хийж гүйцэтгэнэ. Хөрөнгө оруулалт зайлшгүй нэмэлтээр хийх тохиолдолд саналаа боловсруулан нийслэлийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулах ажлыг зохион байгуулна.

6.6. Газар нь эд хөрөнгө, бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа хуулиараа төрийн нууцад хамааралтай тусгай зориулалтын тоног төхөөрөмж, байгууламж, ажил үйлчилгээг холбогдох хууль, дүрэмд нийцүүлэн, бусад бараа ажил үйлчилгээг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг баримтлан хэрэгжүүлнэ.

Долоо. Хяналт

7.1. Холбогдох хууль тогтоомж, журмын дагуу үйлдвэрийн газрын үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт гаргуулна.

7.2. Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалт, ашиглалт болон санхүүгийн үйл ажиллагаанд Нийслэлийн өмчийн харилцааны газар, "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын дарга хяналт тавьж ажиллана.

7.3. Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг ахлах нягтлан бодогч хариуцан хэрэгжүүлнэ.

Найм. Бичиг баримтыг хадгалах

8.1. Газар нь дараах бичиг баримтыг хадгална:

8.1.1. Газрын дүрэм, түүнд орсон нэмэлт өөрчлөлттэй холбоотой холбогдох газруудын шийдвэр, тогтоол, улсын бүртгэлийн гэрчилгээ болон бусад гэрчилгээ сертификатууд;

8.1.2. Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангууд, түүнд хийгдсэн аудитын дүгнэлт, зөвлөмжүүд;

8.1.3. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримтууд, түүнд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох бичиг баримтууд;

8.1.4. Үйлдвэрлэл, технологи, норм нормативууд түүнтэй холбогдох дүрэм, журам, зааврууд, бусад бичиг баримтууд;

8.1.5. Хурлын тэмдэглэл, шийдвэр, даргын гаргасан тушаал, шийдвэрүүд;

8.1.6 Гэрээ;

8.1.7. Байгууллагаас явуулсан ирсэн, явуулсан бичиг;

8.1.8 Байгууллагын Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуух бусад ач холбогдол бүхий баримт бичгүүд;

8.2. Дээрх бичиг баримтыг зохих журмын дагуу холбогдох этгээдээс хүлээн авч хадгалах, эрх бүхий этгээдэд танилцуулах, архивт шилжүүлэх зэрэг ажлыг байгууллагын даргын туслах, бичиг хэрэг хариуцсан ажилтан эрхлэн гүйцэтгэнэ.

Ес. Хариуцлага

9.1. Монгол Улсын хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн тогтоол, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн захирамжийн биелэлтийг хэрэгжүүлэх явцад буруу шийдвэр гаргаж бусдад хохирол учруулсан нь шүүхээр тогтоогдсон бол холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

9.2. Газрын дарга нь эрх мэдлээ хэтрүүлэх буюу урвуулан ашиглаж байгууллагад хохирол учруулсан бол уг хохирлыг байгууллагын дарга өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцна.

9.3. Газрын дарга нь Монгол улсын хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчвөл хариуцлага хүлээлгэнэ.

9.4 Газрын ажилтнууд байгууллагын дүрэм, дотоод журам, ажлын байрны тодорхойлолтод заасан үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

Арав. Бусад

10.1. Хуульд нийцүүлэн дүрэмд тусгаснаас бусад асуудлыг хуулиар зохицуулна.

10.2. Газрын энэхүү дүрэм нь Монгол улсын Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгэгдсэн өдрөөсөө эхлэн хүчин төгөлдөр болно.

10.3 Энэхүү дүрмэнд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн хурлын тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

10.4 Дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр холбогдох байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.

----- о О о -----